# МИД Төсөл

**Малын индексжүүлсэн даатгал төслийн товч танилцуулга**

Төсөл Хэрэгжүүлэх Нэгж
2009 он

# МИД Төсөл

1. **Малын индексжүүлсэн даатгал төслийн үйл ажиллагаа, үр дүн**
2. **Бүтэц, зохион байгуулалт**
3. **Санхүүжилт**

## Малын индексжүүлсэн даатгал төслийн үйл ажиллагаа, үр дүн

Төсөл хэрэгжүүлэх болсон үндэслэл:

- ХАА-н салбар нь МУ-ын эдийн засгийн чухал салбар бөгөөд хүн амын 50 гаруй хувь нь мал аж ахуйн салбараас тодорхой хэмжээний орлого олдог.
- Гэсэн хэдий ч бэлчээрийн мал аж ахуй нь байгалийн гамшиг, зудаас ихээхэн хамааралтай бөгөөд байгалийн томоохон гамшиг нь малчин өрх, орон нутгийн байгууллага, улсын эдийн засагт муугаар нөлөөлдөг.
- Малын даатгалын уламжлалт тогтолцоо нь эрсдэл өндөртэй тул даатгалын компаниуд мал даатгахаа больсон.
- Мал аж ахуйг зуд, байгалийн гамшигаас хамгаалах даатгалын шинэ тогтолцоо шаардлагатай болсон.

## Малын индексжүүлсэн даатгал төслийн үйл ажиллагаа, үр дүн

Малын хорогдлоос учрах эдийн засгийн хохирол маш өндөр

- *2000-2002 онуудад нийт 11 сая мал хорогдсон,*
- *2001 оны малын хорогдлын хохирол ДНБ-ний 15%,*
- *2000-2002 малын хорогдлын хэмжээ нь жилийн ҮНБ-ний 7% байсан*

тул даатгалын хуучин тогтолцоо хэрэгжих боломж муутай.

Монгол улсын Засгийн газар Дэлхийн Банк болон бусад гадаад, дотоодын өндөр мэргэшсэн зөвлөхүүдийн тусламжтайгаар 2001 оноос хойш даатгалын оновчтой шинэ арга механизмыг судлаж ирсэн.

# Индексжүүлсэн даатгал гэж юу вэ?

- Индекст суурилсан даатгал гэдэг нь байгалийн давагдашгүй хүчин зүйлээс учрах эрсдэлээс хамгаалах зорилготой бөгөөд даатгалын нэгж тохиолдолд бус, тодорхой үзүүлэлтүүдэд үндэслэн хохирлын нөхөн төлбөрийг олгодог даатгалын хэлбэр юм.
- Өөрөөр хэлбэл нэгж даатгуулагчийн хохирлыг төлөхдөө тухайн төрлийн даатгалын бүс нутгаарх хохирлын хэмжээ, хохирол учрахад нөлөөлсөн хүчин зүйлсийн хэмжээ зэрэг хохирлын шууд бус үзүүлэлтүүдэд тулгуурлан даатгалын нөхөн төлбөрийг төлдөг үндсэн зарчимтай.
- Энгийнээр хэлбэл нэг малчин, нэг айлаас хамаарахгүй, нилээд хэдэн малчдаас хамаарсан зудын эсрэг даатгал юм.

# МИД төслийн хамрах хүрээ ба хугацаа
# 2006, 2007, 2008, 2009, 2010, 2011, 2012

- Төслийн эхний жилүүдэд туршилтыг Баянхонгор, Увс, Хэнтий гэсэн 3-н аймагт хэрэгжүүлсэн.
- **2009-2010 оны МИД-ын борлуулалтад Сүхбаатар аймгийг нэмж хамруулснаар нийт 4 аймагт хэрэгжихээр боллоо.***
- Тус аймгуудыг газар зүйн тархалт, хөдөө аж ахуй, цаг агаарын онцлог, малын хорогдлын эрсдлийн ялгаатай байдлыг харгалзан сонгосон
- МИД-ыг үндэсний хэмжээнд нэвтрүүлэх МИД 2 төсөл 2011-2013 онуудад хэрэгжүүлэхийг зорин ажиллаж байна.



## Малын индексжүүлсэн даатгал туршилтын төсөлд оролцогч талууд

- Малчид
- Даатгалын компаниуд ба даатгалын төлөөлөгч нар
- Төслийн удирдах хороо
- Төсөл хэрэгжүүлэх нэгж
- Орон нутгийн удирдлага
- Санхүүгийн зохицуулах хороо
- Үндэсний статистикийн хороо
- МУЗГ ба Сангийн Яам
- Дэлхийн Банк ба бусад донорууд
- Банк ба банк бус санхүүгийн байгууллагууд

## Даатгалын онцлог



# МИД-ын хэрэгжилт

**2006 оны борлуулалт**

**Даатгуулсан малчны тоо:** 2422

Баянхонгор аймаг:949 (8.3%)
Увс аймаг:1184 (12%)
Хэнтий аймаг:279 (4.2%)

**Даатгуулсан малын тоо**: 292000 (5.5%)

**2007 оны борлуулалт**

**Даатгуулсан малчны тоо :** 3705

Баянхонгор аймаг:1708 (14.7%)
Увс аймаг:1431 (14.2%)
Хэнтий аймаг:566 (7.9%)

**Даатгуулсан малын тоо**: 409000 (5.8%)

**2008 оны борлуулалт**

**Даатгуулсан малчны тоо :** 4047

Баянхонгор аймаг:1910 (16%)
Увс аймаг:388 (13%)
Хэнтий аймаг:749 (10%)

**Даатгуулсан малын тоо**: 489800 (6%)

# МИД-ын хэрэгжилт

**2006 он**

3 даатгалын компани

144 даатгалын төлөөлөгч

**Даатгалын хураамжийн хэмжээ:** 85.5 сая төгрөг

**2007 он**

4 даатгалын компани

154 даатгалын төлөөлөгч

**Даатгалын хураамжийн хэмжээ:** 129.1 сая төгрөг

**2008 он**

4 даатгалын компани

183 даатгалын төлөөлөгч

**Даатгалын хураамжийн хэмжээ:** 140.1 сая төгрөг

## Нөхөн төлбөр

| 2006 оны борлуулалт | 2007 оны борлуулалт |
| --- | --- |
| Даатгуулсан малчин: 2422 | Даатгуулсан малчин: 3705 |
| Нөхөн төлбөр авсан малчин: 47 | Нөхөн төлбөр авсан малчин: 1742 |
| Даатгалын хураамж: 85.5 сая | Даатгалын хураамж: 129.1 сая |
| Нөхөн төлбөрийн хэмжээ: 1.8 сая | Нөхөн төлбөрийн хэмжээ: 380 сая |
| Борлуулалт хийгдсэн сум: 3 аймгийн 56 сум | Борлуулалт хийгдсэн сум: 3 аймгийн 56 сум |
| Нөхөн төлбөр олгогдсон сум: 2 аймгийн 2 сум | Нөхөн төлбөр олгогдсон сум: 3 аймгийн 35 сум |

## МИД-ын хураамж ба нөхөн төлбөр

- Сумын дүнгээр малын хорогдлын хувь босго үзүүлэлтээс (ҮДБ-ний хувьд 6%, ГХБ-ний хувьд 25%,30%) хэтэрсэн тохиолдол бүрт ҮДБ болон ГХБ-ийг худалдан авсан даатгуулагч нөхөн төлбөр авна.
- Гэхдээ даатгуулагчид учирсан хохирлын хэмжээнд биш, харин тухайн төрлийн малын хорогдол сумын хэмжээнд ямар байгааг үндэслэн нөхөн төлбөр олгох юм.
- Нөхөн төлбөрийг тооцохдоо ҮДБ-д даатгуулсан бол малчны сонгосон малын үнэлгээнээс, ГХБ-д даатгуулсан бол тухайн малын ҮСХ-ноос оны эцсийн байдлаар тогтоосон үнэлгээний 50 хувиас тооцно.

# МИД-ын онцлог

- Энэхүү даатгалын онцлог нь малыг зүслэн нэг бүрчлэн даатгахгүй бөгөөд хорогдсон малд ямар нэгэн акт баримт шаардахгүй зөвхөн аймаг сумын захиргаа, Үндэсний статистикийн хороотой хамтран зохион байгуулдаг мал тооллогын дүн мэдээнд үндэслэдэг учраас ямар нэг эргэлзээгүй баталгаатай байдаг юм.
- Сумын хэмжээнд их хэмжээний хорогдол гарсан хэдий ч Малын индексжүүлсэн даатгалд хамрагдсан малчин өөрийн хичээл зүтгэлээр малаа хорогдолгүй, онд мэнд оруулсан бол даатгалын нөхөн төлбөр авна.
- Харин тухайн малчин малаа их хэмжээгээр хорогдуулсан ч сумын хорогдлын хэмжээ нь тогтоосон босго үзүүлэлтэд хүрэхгүй бол нөхөн төлбөр авахгүй. Өөрөөр хэлбэл бага хэмжээний эрсдэлийг малчид өөрсдөө хариуцаж байгаа хэрэг юм. Тодруулбал Малын индексжүүлсэн даатгал нь малчдын хүч чадлаас давсан гамшигийн шинжтэй эрсдэлээс малчдыг хамгаална.

# Мал тооллого

Даатгалын нөхөн төлбөр олгох гол үзүүлэлт нь сумын малын хорогдлын хувь юм. Энэхүү үзүүлэлтийг тооцоолж гаргахдаа даатгуулсан оны жилийн эцсийн болон дараа оны хагас жилийн мал тооллогын дүн мэдээг үндэслэдэг.

Сумын малын хорогдлын хэмжээ **СМХ =** $\frac{X+A}{B} * 100\%$

**В** – ҮСХ-ноос 2009 оны 12 дугаар сард зохион явуулах жилийн эцсийн мал тооллогын албан ёсны дүн (малын төрөл тус бүрээр);

**Х** - ҮСХ-ноос 2010 онд зохион явуулах хагас жилийн мал тооллогын том малын зүй бус хорогдолын дүн. (малын төрөл тус бүрээр);

**А** - ҮСХ-ноос 2010 онд зохион явуулах хагас жилийн мал тооллогын алдсан хулгайлагдсан том малын дүн. (малын төрөл тус бүрээр);

# МДНТД

**Баянхонгор** Малчид

**Сүхбаатар** Малчид

**Увс** Малчид

**Хэнтий** Малчид

**дундын данс**

# Даатгалын борлуулалтын хугацаа



# 2. МИД-ын бүтэц, зохион байгуулалт




# 2. МИД-ын бүтэц, зохион байгуулалт

**Төслийн удирдах хороо**

- Сангийн яам
- Санхүүгийн зохицуулах хороо
- Хууль, зүй дотоод хэргийн яам
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
- Үндэсний статистикийн хороо
- Онцгой байдлын ерөнхий газар
- Хөдөө аж ахуйн Их сургууль
- Төсөл хэрэгжүүлэх нэгж

**Төсөл Хэрэгжүүлэх нэгж**

Төсөл хэрэгжүүлэх нэгж нь таван бүрэлдэхүүн хэсэгтэй бөгөөд нийт 11 ажилтантай болно. Үүнд;

- ТХН-ийн захирал
- Даатгалын асуудал хариуцсан зохицуулагч, мэргэжилтэн
- Чадавхийг бэхжүүлэх, эрх зүйн асуудал хариуцсан зохицуулагч
- Мониторинг, үнэлгээний мэргэжилтэн
- Нягтлан, санхүү худалдан авалт, удирдлагын мэдээллийн системийн мэргэжилтэн
- Захиргааны туслах ажилтан

**Орон нутгийн салбар**

Төсөл хэрэгжүүлэх нэгж нь 4-н аймгийн 69-н суманд хэрэгжиж байгаа бөгөөд аймгийн зохицуулагч, сумын ажилтантай болно.

- Дөрвөн аймгийн зохицуулагч
- 69-н суманд тус бүр нэг нэг ажилтан

## МИД-ын нэмэлт санхүүжилт

Малын индексжүүлсэн даатгал
төслийн санхүүжилтийн эх үүсвэр:

- **Дэлхийн Банкны** хөнгөлттэй /нөхцөлт/зээл
- **Японы засгийн газрын** хамтран санхүүжүүлэх буцалтгүй тусламж
- **“Швейцарийн хөгжлийн агентлаг”-ын** буцалтгүй тусламж
- **“Монгол Улсын засгийн** газар”-ын санхүүжилт

# Анхаарал тавьсанд баярлалаа!

Төслийн талаар нэмэлт мэдээллийг манай Вэб хуудаснаас үзнэ үү.
www.iblip.mn

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ
УЛААНБААТАР ХОТ, МОНГОЛ УЛС
Утас: 976-70112005
Е-мэйл: info@iblip.mn